



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

24 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022 /52/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Б.Бямбатогтох
Утас: 70350757 Цахим хаяг: byambatogtokhb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|--|----|
| 1. Аудитын санал дүгнэлт | 2 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 4 |
| 3. Аудитын тайлан | 10 |
| 3.1 Ерөнхий зүйл | 10 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт | 10 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 11 |
| 3.4 Материаллаг байдал | 11 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга | 12 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв | 12 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг | 13 |
| 3.8 Аудитын гол асуудал | 13 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 13 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 14 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 14 |
| 4. Аудитын илрүүлэлт | 14 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл | 15 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 82
танай _____-ны № _____-г

ОРХОН АЙМГИЙН 24 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ж.ДАВААСҮРЭН ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 24 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

24 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|--|-------------------------|-----------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 81,629,147.82 | 75,909,525.94 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 338,300.00 | - |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 338,300.00 | - |
| 3121 | Төгрөг | 338,300.00 | - |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 338,300.00 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 81,290,847.82 | 75,909,525.94 |
| 351 | Түүхий эд материал | 76,750,877.82 | 72,515,495.94 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 76,750,877.82 | 72,486,445.94 |
| 35130 | Эм боох материал | - | 29,050.00 |
| 354 | Хангамжийн материал | 4,539,970.00 | 3,394,030.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 820,250.00 | 517,150.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 3,340,680.00 | 2,599,980.00 |
| 35460 | Хүнсний материал | 379,040.00 | 276,900.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 938,420,418.81 | 912,464,764.43 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 938,420,418.81 | 912,464,764.43 |
| 392 | Биет хөрөнгө | 826,240,418.89 | 800,334,764.55 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 825,501,320.32 | 825,501,320.32 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (33,434,942.25) | (50,265,486.09) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 41,835,447.35 | 41,835,447.35 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (27,950,378.22) | (32,462,986.38) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 38,754,409.70 | 38,754,409.70 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (27,161,921.88) | (31,001,361.22) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 10,142,609.87 | 10,142,609.87 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (1,446,126.00) | (2,169,189.00) |
| 393 | Биет бус хөрөнгө | 112,179,999.92 | 112,129,999.88 |
| 39301 | Програм хангамж | 400,000.00 | 400,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (100,000.08) | (150,000.12) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 111,880,000.00 | 111,880,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,020,049,566.63 | 988,374,290.37 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | 825,936.70 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 825,936.70 |
| 413 | Өглөг | - | 825,936.70 |
| 4136 | Бусад өглөг | - | 825,936.70 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 483,000.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 342,936.70 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 401,520,050.63 | 369,018,837.67 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 401,520,050.63 | 369,018,837.67 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 35,495,290.15 | 2,994,077.19 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 35,495,290.15 | 35,495,290.15 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (32,501,212.96) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 366,024,760.48 | 366,024,760.48 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 401,520,050.63 | 369,844,774.37 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 434,503,600.00 | 430,330,700.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 8,121,900.00 | 914,800.00 |

| | | | |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 8,121,900.00 | 914,800.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 8,121,900.00 | 914,800.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 8,121,900.00 | 914,800.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 426,381,700.00 | 429,415,900.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 404,609,500.00 | 407,203,800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 404,609,500.00 | 407,203,800.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 440,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 300,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 140,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 21,772,200.00 | 21,772,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 21,772,200.00 | - |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | - | 21,772,100.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 452,571,602.96 | 462,831,912.96 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 452,571,602.96 | 462,831,912.96 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 442,579,862.96 | 454,460,629.96 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 329,471,400.00 | 340,474,021.70 |
| 210101 | Үндсэн цалин | 302,603,467.00 | 238,643,285.70 |
| 210102 | Нэмэгдэл | 11,538,716.00 | 86,335,198.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 102,514.00 | 680,677.00 |
| 210104 | Урамшуулал | 15,226,703.00 | 14,814,861.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 43,077,214.00 | 45,631,723.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,898,914.00 | 31,678,223.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,294,700.00 | 3,488,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,635,300.00 | 2,790,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 658,900.00 | 697,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,589,400.00 | 6,976,700.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 11,857,056.00 | 13,913,519.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,056,124.00 | 5,849,372.00 |
| 210302 | Түлш, халаалт | 5,490,555.00 | 4,930,065.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,310,377.00 | 3,134,082.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 8,099,150.00 | 11,688,631.88 |
| 210401 | Бичиг хэрэг | 271,450.00 | 1,681,650.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 170,500.00 | 423,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,707,200.00 | 721,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,937,900.00 | 3,054,050.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 12,100.00 | - |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 5,808,231.88 |
| 2105 | Нормативт зардал | 21,412,770.00 | 15,517,180.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 64,750.00 | 303,250.00 |
| 210502 | Хоол, хүнс | 21,193,020.00 | 15,213,930.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 155,000.00 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 316,100.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 316,100.00 | - |
| 2107 | Томилолт, зочны зардал | 131,800.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 131,800.00 | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 705,000.00 | - |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 705,000.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 27,509,372.96 | 27,235,554.38 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 200,000.00 | 849,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,865,650.00 | 430,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 25,443,722.96 | 25,955,654.38 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 9,991,740.00 | 8,371,283.00 |

| | | | |
|-------------|---|------------------------|------------------------|
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 250,000.00 | 150,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 250,000.00 | 150,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 208,660.00 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 208,660.00 | - |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 9,533,080.00 | 6,709,981.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,533,080.00 | 6,709,981.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 1,511,302.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 1,511,302.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | (18,068,002.96) | (32,501,212.96) |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | - | - |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 575,210.00 | - |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 575,210.00 | - |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | (575,210.00) | - |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | (18,643,212.96) | (32,501,212.96) |

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|----------------------|---|
| C01 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 618,529,516.00 | 366,024,760.48 | 54,126,403.11 | 1,038,680,679.59 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 618,529,516.00 | 366,024,760.48 | 54,126,403.11 | 1,038,680,679.59 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (18,631,112.96) | (18,631,112.96) |
| C08 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 618,529,516.00 | 366,024,760.48 | 35,495,290.15 | 1,020,049,566.63 |
| D01 | 2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 618,529,516.00 | 366,024,760.48 | 35,495,290.15 | 1,020,049,566.63 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 618,529,516.00 | 366,024,760.48 | 35,495,290.15 | 1,020,049,566.63 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (32,501,212.96) | (32,501,212.96) |
| D09 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 618,529,516.00 | 366,024,760.48 | 2,994,077.19 | 987,548,353.67 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 434,503,600.00 | 430,330,700.00 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | - | - |
| 110 | Орлогын албан татвар | - | - |
| 141001 | Гадаадын санхүүгийн зээлийн эх үүсвэр | | |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 426,381,700.00 | 429,415,900.00 |

| | | | |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 300,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 140,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 21,772,200.00 | 21,772,100.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 452,571,602.96 | 462,831,912.96 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 452,571,602.96 | 462,831,912.96 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 442,579,862.96 | 454,460,629.96 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 329,471,400.00 | 340,474,021.70 |
| 210101 | Үндсэн цалин | 302,603,467.00 | 238,643,285.70 |
| 210102 | Нэмэгдэл | 11,538,716.00 | 86,335,198.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 102,514.00 | 680,677.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 43,077,214.00 | 45,631,723.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,898,914.00 | 31,678,223.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,294,700.00 | 3,488,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,635,300.00 | 2,790,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 658,900.00 | 697,700.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 11,857,056.00 | 13,913,519.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,056,124.00 | 5,849,372.00 |
| 210302 | Түлш, халаалт | 5,490,555.00 | 4,930,065.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 8,099,150.00 | 11,688,631.88 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 170,500.00 | 423,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,707,200.00 | 721,500.00 |
| 2105 | Нормативт зардал | 21,412,770.00 | 15,517,180.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 64,750.00 | 303,250.00 |
| 210502 | Хоол, хүнс | 21,193,020.00 | 15,213,930.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 155,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 316,100.00 | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 705,000.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 27,509,372.96 | 27,235,554.38 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 9,991,740.00 | 8,371,283.00 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | - | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 250,000.00 | 150,000.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 1,511,302.00 |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | = | = |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 575,210.00 | - |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 338,300.00 |

| | | | |
|----|---|------------|---|
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 338,300.00 | - |
|----|---|------------|---|

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|-----------------------|--|-----------------------|-------------|-----------------------|-------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 431,548,600 | 419,567,084 | 428,975,900 | 420,754,617 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 431,548,600 | 419,567,084 | 428,975,900 | 420,754,617 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 431,398,600 | 419,417,084 | 428,975,900 | 420,754,617 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 329,471,400 | 329,471,400 | 340,136,800 | 340,131,085 |
| 210101 | Үндсэн цалин | 213,622,600 | 302,603,467 | 196,343,100 | 238,300,349 |
| 210102 | Нэмэгдэл | 86,599,500 | 11,538,716 | 112,342,300 | 86,335,198 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,480,000 | 102,514 | 2,965,800 | 680,677 |
| 210104 | Урамшуулал | 26,769,300 | 15,226,703 | 28,485,600 | 14,814,861 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 43,077,300 | 43,077,214 | 46,784,200 | 45,631,723 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,898,500 | 29,898,914 | 32,830,700 | 31,678,223 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,294,700 | 3,294,700 | 3,488,400 | 3,488,400 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,635,800 | 2,635,300 | 2,790,700 | 2,790,700 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 658,900 | 658,900 | 697,700 | 697,700 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,589,400 | 6,589,400 | 6,976,700 | 6,976,700 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 20,140,500 | 11,857,056 | 20,140,500 | 13,430,519 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,295,900 | 3,056,124 | 5,295,900 | 5,366,372 |
| 210302 | Түлш, халаалт | 7,283,300 | 5,490,555 | 7,283,300 | 4,930,065 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,561,300 | 3,310,377 | 7,561,300 | 3,134,082 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 11,732,500 | 9,492,724 | 1,722,600 | 1,664,650 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,295,900 | 3,056,124 | 105,200 | 66,500 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 170,500 | 170,500 | 311,400 | 423,200 |
| 210404 | Ном, хэвлэл | 80,700 | 80,700 | 65,800 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 5,953,300 | 5,953,300 | 371,900 | 389,500 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 232,100 | 232,100 | 868,300 | 785,450 |
| 2105 | Нормативт зардал | 21,898,800 | 21,898,740 | 15,753,000 | 15,588,290 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 169,100 | 169,100 | 60,500 | 60,500 |
| 210502 | Хоол, хүнс | 21,018,000 | 21,017,940 | 15,111,800 | 15,111,790 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 711,700 | 711,700 | 580,700 | 416,000 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,631,700 | 316,100 | 1,631,600 | 1,631,600 |
| 210604 | Урсгал засвар | 1,631,700 | 316,100 | 1,631,600 | 1,631,600 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 131,800 | 131,800 | 107,500 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 131,800 | 131,800 | 107,500 | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 705,000 | 705,000 | - | - |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 705,000 | 705,000 | | |

| | | | | | |
|-------------|---|-------------|-------------------|-------------|-------------|
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,609,600 | 2,467,050 | 2,699,700 | 2,676,750 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 342,500 | 200,000 | 849,900 | 849,900 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,267,100 | 2,267,050 | 1,849,800 | 1,826,850 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 150,000 | 150,000 | - | - |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 150,000 | 150,000 | - | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 150,000 | 150,000 | | |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 448,153,900 | 416,639,960 | 428,975,900 | 427,464,598 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 426,381,700 | 404,400,540 | 407,203,800 | 405,692,498 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 426,381,700 | 404,400,540 | 407,203,800 | 405,692,498 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 21,772,200 | 12,239,420 | 21,772,100 | 21,772,100 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 21,772,200 | 12,239,420 | 21,772,100 | 21,772,100 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | - | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 338,300.00 | | - |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | | | |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | 1 | 1 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 32 | 32 | 32 | 32 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 23 | 23 | 23 | 23 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 8 | 8 | 8 | 8 |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | - | - | 200 | 200 |
| 631 | СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА | - | - | 200 | 200 |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | - | - | 200 | 200 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 32 | 32 | 32 | 32 |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 19 | 19 | 19 | 19 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 1 | 1 | 1 | 1 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 12 | 12 | 12 | 12 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|------------|--|----------|-------------------|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | 440,000.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 440,000.00 |

| | | | |
|-------------|--|------------|------------|
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | - | 440,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 440,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | - | 140,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 300,000.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | 440,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 440,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 300,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 140,000.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 338,300.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 338,300.00 | - |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу 24 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Бямбатогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

24 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

24 дүгээр цэцэрлэг нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх байгууллага юм.

Суралцагчдын сурах үйлийн дэмжиж, хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх арилгахад бүх талын оролцоо, хамтын ажиллагааг хангаж, сургалт үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах зорилготой ба дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллажээ.

- Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр, хэрэгжүүлэх зөвлөмжийг хэрэгжүүлэн, өөрийн онцлог, хэрэгцээ, шаардлагыг тусгасан үзэл баримтлалд тулгуурлан хөтөлбөрийг боловсруулан, агуулгын хоцрогдлыг арилгах, сургалт үйл ажиллагааг танхимаар ба зайнаас зохион байгуулах,
- Багш ажиллагсдын мэдээлэл харилцааны технологийг ашиглах чадварыг нэмэгдүүлж, цахим орчинд зөв зохистой хэрэглээг хэвшүүлэх,
- Багш нарыг тасралтгүй хөгжих, нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллах нөхцөл боломжоор хангахад дэмжлэг үзүүлэх, ажилтан албан хаагчдын ёс зүйн харилцааны хэм хэмжээг мөрдөж, үйлчилгээний чанарыг эрхэмлэн, олон талт хамтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах,
- Сургалтын байгууллагын орчны стандартыг мөрдлөг болгон, орчны эрсдэлийн үнэлгээ хийж, аюулгүй байдлыг ханган эрүүл ахуйн зөв дадал, хэвшил эзэмшүүлэх,
- Байгууллагын менежментийг сайжруулан, хүүхдийн хөгжил хамгааллын асуудлаар эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах гэрээ байгуулж тэдний үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх,
- Хүүхдийн бүхий л талын хөгжлийг дэмжих, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанарыг сайжруулах, эрүүл, аюулгүй, шим тэжээллэг хоол хүнсээр үйлчлэх.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын хууль тогтоомж, Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, ТБОНӨХБАҮХАТХууль зэрэгт өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

24 дүгээр цэцэрлэг 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 448,402.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,726.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5,044.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

24 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 31,675.3 мянган төгрөгөөр буюу 3.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|--------------------|------------------|-------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бараа материал | 81,290.8 | 75,909.5 | (5,381.3) |
| Үндсэн хөрөнгө | 938,420.4 | 912,464.8 | (25,955.6) |
| Нийт хөрөнгө | 1,020,049.6 | 988,374.3 | (31,675.3) |
| Өр төлбөр | | 825.94 | 825.94 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,020,049.6 | 988,374.3 | (31,675.3) |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 1,020,049.6 | 988,374.3 | (31,675.3) |

Бараа материалын данс 75,909.5 мянган төгрөг болж 5,381.3.1 мянган төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материалыг акталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 912,464.8 мянган төгрөг болж 25,955.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд томоохон хөрөнгө бүртгээгүй, 25,955.6 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл тооцсонтой холбоотой байна.

Тайлант онд 825.94 мянган төгрөгийн байгууллага болон хувь хүнд өгөх өр төлбөртэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 988,374.3 мянган төгрөг болж 31,675.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

24 дүгээр цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 4,172.9 мянган төгрөгөөр буюу 1.0 хувиар буурсан, нийт зардал өмнөх оноос 9,434.4 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар тус тус өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

24 дүгээр цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 627,684.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 627,684.2 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 179,281.3 мянган төгрөгөөр бууруулан 448,402.9 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд төсөвт 1 удаа тодотгол хийж 19,427.0 мянган төгрөгөөр бууруулж, 428,975.9 мянган төгрөгөөр баталжээ. Тодотголоор хоол хүнсний зардлыг бууруулжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр 407,203.8 мянган төгрөгийг улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгээр, орон нутгийн төсвөөс 21,772.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 420,754.6 мянган төгрөгийг зарцуулж, 8,221.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 420,754.6 мянган төгрөг буюу 98.1 хувьтай байгаа байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 6,709.9 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл 1,152.5 мянган төгрөг, нормативт зардал 164.7 мянган төгрөг, томилолтын зардлыг 107.5 мянган төгрөг, Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс 82.85 мянган төгрөгийг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн БСУГ-аас 140.0 мянган төгрөгийн бичиг хэрэг, 300.0 мянган төгрөгийн хог хаягдал зайлуулах санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

24 дүгээр цэцэрлэг нь 2021 онд нийт 387,906.4 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй, 387,906.4 мянган төгрөгийн 149 мэдээллийг ил тод байршуулж хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин ажлын хувцас худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын 1.4 дэх заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3,011.7 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмж хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|-----------------|---------------------|---------|---------|---------|-------|-----|------|
| | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | хувь |
| Акт | | | | | | | |
| Албан шаардлага | 1 | 3,011.7 | 1 | 3,011.7 | | | |
| Зөвлөмж | 1 | 0 | 1 | 0 | | | |
| Нийт дүн | 2 | 3,011.7 | 2 | 3,011.7 | | | |

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,052.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 886.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 116.0 мянган төгрөгт 1 албан шаардлага, 1,049.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

- ЭБЦТС ТӨХК-д 483.0 мянган төгрөгийн өглөгийг бүртгээгүйг аудитын явцад залруулж өглөгөөр бүртгүүлж тайлагнуулсан.

- Нийгмийн даатгалын шимтгэлийн даатгуулагчийн 1 хувийн зөрүү 342.9 мянган төгрөгийг ажилчдад буцаан олгоогүйг аудитын явцад ажилчдад өгөх өглөгөөр бүртгүүлж тайлагнуулсан.
- 60.5 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгслийг бараа материалын тайлангийн эм боох материалд бүртгээгүйг аудитын явцад залруулж тайлагнуулсан.

4.3 Албан шаардлага

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд 116.0 мянган төгрөгийн нормын хувцас худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-д "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх," гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Тайлант онд и-баримтгүй 1,049.7 мянган төгрөгийн ажил гүйлгээ хийж бүртгэж тайлагнасан байна. Энэ Татварын ерөнхий хуулийн 28.5-д "дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтгүй ажил гүйлгээ бүртгэж, тайлагнахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|-----|-------------------------------------|----------------------|-----|-----------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|-----------------------|---|---------|---|-------|--|--|---|-------|---|---------|
| 1 | 24 дүгээр цэцэрлэг | 5 | 2,052.4 | 3 | 886.4 | | | 1 | 116.0 | 1 | 1,049.7 |
|---|-----------------------|---|---------|---|-------|--|--|---|-------|---|---------|